

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай*

Монгол Улсын Их Хурлаас Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Хууль хэрэгжсэн хугацаанд гамшиг, аюулт үзэгдэл, ослын давтамж, эрчим өөрчлөгдөж, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан гамшгийн эрсдэл нэмэгдэхийн зэрэгцээ хууль хэрэгжүүлэх явцад эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, хийдэл, чиг үүргийн давхардал гарах зэрэг хүндрэлүүд үүсэх болсон.

Сүүлийн арван жилд Монгол Улсад нийт 50,215 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, 4,491 хүн амь насаа алдаж, 991,194 хүн өвчилж, 11.5 сая толгой мал хорогдсон. Мөн ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2016 онтой харьцуулахад 2025 онд 2.4 дахин нэмэгдсэн нь гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийг даван туулах үндэсний чадавхыг бэхжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2025 онд хийсэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр гамшиг, гамшгийн эрсдэл, эмзэг байдал зэрэг нэр томъёоны тодорхойлолт олон улсын жишигтэй нийцээгүй, гамшгийн үеийн удирдлагын тогтолцоонд чиг үүргийн давхардал, тодорхой бус байдал үүссэн, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, гамшгаас хамгаалах сургалт, хяналтын тогтолцооны эрх зүйн үндэс дутмаг, хүч хэрэгсэл дайчлах, нөхөн олговор олгохтой холбоотой зохицуулалт тодорхой бус зэрэг асуудлыг тодорхойлсон.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах зорилтууд тусгагдсан.

Дээрх нөхцөл байдал, хууль зүйн болон практик шаардлагыг харгалзан Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 7 зүйлтэй бөгөөд Гамшгаас хамгаалах тухай хуулийн нийт зохицуулалтын 36 хувьд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа болно. Хуулийн төсөлд дараах үндсэн өөрчлөлтийг тусгасан. Үүнд:

Нэгдүгээрт, гамшиг, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, осол, гамшгийн онцгой нөхцөл байдал зэрэг зарим нэр томъёоны тодорхойлолтыг НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлж, ойлгомжтой болгож, зарим нэр томъёог шинээр нэмж хуульчилсан.

Хоёрдугаарт, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг боловсронгуй болгож, бэлэн байдлын зэргийг байнгын болон өндөржүүлсэн гэсэн хоёр зэрэгтэй болгон шинэчилж, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шаардлага, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Гуравдугаарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хамрах хүрээг байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан шинэчилж, гамшгаас хамгаалах хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхой болгосон тодорхой болгосон.

Дөрөвдүгээрт, гамшгаас хамгаалах сургалт, мэдээлэл, сурталчилгаа, гамшгийн эрсдэлийн үнэлгээ зэрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилт, хяналттай холбоотой чиг үүргийг засаг захиргааны нэгж, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод гүйцэтгүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Мөн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэд, сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Тавдугаарт, гамшгийн үеийн удирдлагын тогтолцооны давхардал, хийдлийг арилгаж, Засгийн газар, Засгийн газрын гишүүн, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, бүрэн эрхийн уялдаа холбоог тодорхой болгосон.

Зургаадугаарт, хүч хэрэгсэл дайчлах, иргэн, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг гамшгаас хамгаалах зорилгоор ашиглах, түүнтэй холбоотой нөхөн олговрын зохицуулалтыг боловсронгуй болгож, иргэн, хуулийн этгээдийн өмчийн эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг сайжруулсан.

Долоодугаарт, онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулж, мэргэшсэн хүний нөөцийг тогтвортой ажиллуулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгосон.

Наймдугаарт, онцгой байдлын байгууллагын салбар нэгжгүй сумдад гамшгаас хамгаалах асуудал хариуцсан алба хаагч ажиллуулах, томоохон аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гэрээт нэгж болон байцаагчийг ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зохицуулалтыг тусгасан.

Есдүгээрт, аймаг, сум, нийслэл, дүүрэгт Гамшгийн эрсдэлийг бууруулах сан байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон.

Аравдугаарт, гамшиг ослын шинжгүй дуудлагаар ажиллахад гарсан зардлыг дуудлага өгсөн иргэн, хуулийн этгээд хариуцах замаар төрөөс гарч буй үргүй зардлыг багасгах, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн хохирлыг барагдуулах үйл ажиллагаанд даатгалын компанийн оролцоог хангаж улсын болон орон нутгийн төсөвт учрах хор уршгийг арилгахтай холбоотой ачааллыг бууруулах зэрэг нэмэлт, өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар гамшгаас хамгаалах эрх зүйн орчин олон улсын жишигт нийцэж, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт, удирдлага, хяналт, сургалтын тогтолцоо боловсронгуй болно. Түүнчлэн гамшгийн үеийн удирдлага, зохицуулалтын үр нөлөө дээшилж, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавх нэмэгдэн, гамшгаас урьдчилан сэргийлэх тогтвортой санхүүжилтийн тогтолцоо бүрдэж, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учрах хохирлыг бууруулах эрх зүйн орчин сайжирна гэж үзэж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030 баримт бичиг болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн ба хуулийн төсөлтэй холбогдуулан Галын аюулгүй байдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг тус тус боловсруулсан.

---oOo---